

БАТЛАВ:

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ
“МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРЕЙШН” ХХК-
ИЙН MV-021417 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021417/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6438776/

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ/ /

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРЕЙШН” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../LUO XIAOYONG/
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН/Б.ОДХҮҮ/

АГУУЛГА

УДИРТГАЛ	2
НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /ХАВСРАЛТ 1-2/	5
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	20
АРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	21
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
АРВАН ГУРАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ	24


УДИРТГАЛ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт хэрэгжиж буй MV-021417 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Санжит” нэртэй алтны шороон ордын ажил 2025 оны 07 сарын 30-ны өдрөөс эхлэн болно.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг БОАЖЯ сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаартай тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

“Санжит” алтны шороон орд нь Улаанбаатар хотоос зүүн хойд зүгт 250 км, Дархан хотоос 60 км, Шарын гол сумаас 8 км, Хонгор сумаас 45 км-т, Шарын голын голын хөндийн хойд дэнж, Санжитын амны доод хэсгийг хамарч оршдог.

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

а. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл	Утга
1а.	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэр	“Монголиан токен майнинг инвестмент групп корпорейшн” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019097680 (РД: 6438776)
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Алтны шороон орд
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	УБ хот, СБдүүрэг 1-р хороо, 5-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө, Эко интернэйшнл тауэр, 15 давхар
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Luo XiaoYong, Утас: 77189988, lw@tzkyjt.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Төслийн менежер: Х.Бат-Эрдэнэ 99453205 Байгаль орчны мэргэжилтэн: Б.Одхүү 95334658 baterdene@tzky.mn odkhuu@tzky.mn
2а.	1. Төслийн нэр	“Санжит” алтны шороон ордын ил уурхайн 2025 оны БО-ны менежментийн төлөвлөгөө
	2. Төслийн харьяаллын байршил	Дархан-Уул аймгийн Хонгор сум
	3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд. Баяжуулах	Алтны шороон орд
	4. Төсөл эхэлсэн огноо	2024 оны 08-р сарын 16
	5. Төсөл хэрэгжих хугацаа	3 сар
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	2026 он
	7. Хаалтын дараах зориулалт	бэлчээр
	8. ТЭЗҮ тодотгол баталсан огноо	-
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ (дунджаар)	
	10. Ажилчдын тоо	8
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөв байдал	
	12. Тухайн төсөлд хамаарагдах дэд бүтэц - замын урт - шатахуун түгээгүүрийн тоо - шатахуун агуулахын агууламжийн хэмжээ - тэслэх, дэлбэрэх бодисын үйлдвэрийн хүчин чадал г.м	

б. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгодог тусгай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны товч мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл			Утга
26.	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ дугаар Хүчинтэй хугацаа Талбайн хэмжээ			Ашигт малтмал ашиглах MV-021417 2049.07.08 157.08 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ дугаар хүчинтэй хугацаа			хамаарахгүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн Мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт			хамаарахгүй
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар			-
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд			2023.01.07 06/4800 БОАЖЯ-ны шинжээч С.Нямжав
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд			2024 БОАЖЯ-ны Ерөнхий шинжээч Ц. Уранчимэг
	7. Ус ашиглуулах дүгнэлтийн огноо			2025.06.26 /Дугаар E-2505-000410/
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо			2025 оны 5-р сар
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах			-
	10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн	-
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
		Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн	-
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
	11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар -үндэсний			MNS5914:2008, MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, MNS 3298-90 MNS4048-88, MNS 0012-013-91, MNS 5080-2001 гэх мэт

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /ХАВСРАЛТ 1-2/

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол ба сөрөг болзошгүй сөрөг нөлөө	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
АГААР ОРЧИН						
1	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	ҮАЗ	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашигласан	Тийм	ҮАЗ
2	Орчны агаарын чанар хорт хий, хүнд металлаар бохирдох	Уурхайн бүх тээврийн хэрэгслийн яндангаас гарах хорт хийд тогтмол хяналт тавих, бохирдлыг хэмжих	ОХШХ	Авто тээврийн хэрэгслийг хоногт хамгийн ихдээ 10 цагаар ажлуулсан.	Тийм	ОХШХ гэрээ
3		Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох	ҮАЗ	Уурхайд хүлэмжийн хийн эх үүсвэр болох бүхий техникийн агаар бохирдуулсан албан татварыг техник бүр төлсөн.	Тийм	ҮАЗ
4	Ил уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт	Тээврийн хэрэгслийн хурдны хяналтыг мөрдөж ажиллах, хурд хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг тавьж өгөх	ҮАЗ	Төслийн талбайд хурд хязгаарлах тэмдэг, тэмдэглэгээг суурилуулсан.	Тийм	ҮАЗ
5		Агаар бохирдуулагч эх үүсвэрийг 2 цэг дээр агаарын тоосжилтын хэмжилтийг ОХШХ–т заасны дагуу шинжлүүлэх TSP, PM10, PM2.5	ОХШХ	Байгаль орчны мэргэжлийн гэрээт компаниар гүйцэтгүүлсэн.	Тийм	ОХШХ
6		Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	ҮАЗ	Салхи ихтэй үед хөрс хуулах, ачих, тээвэрлэх үйл ажиллагааг хориглож ажилласан.	Тийм	ҮАЗ
7		Дотоод болон гадаад тээврийн замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд услах, замыг хусаж байх	ҮАЗ	Тээврийн замыг тогтмол усалсан	Тийм	ҮАЗ
8		Овоолго болон барилгын ажлын үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгаа хийнэ.	Ус ашигласны төлбөрт тусгав	Хөрсний овоолго нойтон тул усалгаа шаардаагүй, Барилгын ажил хийгдээгүй.	Тийм	Ус ашигласны төлбөрт орсон

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021417 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Гол ба сөрөг болзошгүй сөрөг нөлөө	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
9		Уурхайн үйл ажиллагаанаас тоосжилт үүсгэж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох	200.0	Бүртгэсэн. Тээвэр хийх машин механизм	Тийм	200.0
10		Уурхайн дотоод тээврийн замыг хайрган хучилттай болгож тоосжилт босохоос сэргийлж замыг урьдчилан бэлдэх	ҮАЗ	Дотоод тээврээр өмнө нь байсан хайрган хучилттай замыг ашигласан.	Тийм	ҮАЗ
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
11	Хөрсний үржил шим алдагдах	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Уулын ажлын зардлаас	Өмнөх ашиглаж дуусаагүй блок дээр ажиллсан учир шимт хөрс хуулаагүй.	Тийм	Уулын ажлын зардлаас
12		Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	Нөхөн сэргээлтийн зардлаас	Тусгайлан ургамалжуулах шаардлага гараагүй	Тийм	Нөхөн сэргээлтийн зардлаас
13		Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулах	ҮАЗ	Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчуулсан	Тийм	ҮАЗ
14		Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	ҮАЗ	Уурхайн замуудыг бүрэн тэмдэгжүүлсэн	Тийм	ҮАЗ
15	Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдал гэх мэт аюултай хог хаягдлын бүртгэл гаргах	ҮАЗ	Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг бүртгэсэн	Тийм	ҮАЗ
16		Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах,	ҮАЗ	Хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлж орон нутагтай хийсэн гэрээний дагуу хогийн цэгт хүргэсэн	Тийм	ҮАЗ
17	Шатах материалаар тослох хөрс бохирдох	Шатахуун түгээх талбайг хатуу хучилттай болгох	ҮАЗ	Шатахуун түгээх болон засвар үйлчилгээ хийх талбайн хөрсийг хамгаалж ус үл нэвчих материалаар хамгаалалт хийсэн.	Тийм	ҮАЗ
18		Ашиглалтын талбайд тос, масло асгарсан тохиолдолд	400.0	Тос масло, шатах тослох материал газарт алдаагүй..техникийн	Тийм	400.0

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021417 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Гол ба сөрөг болзошгүй сөрөг нөлөө	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
		саармагжуулах арга хэмжээ авч, хөрсний бохирдлыг шинжлүүлэх		засварыг тогтсон цэгт хийж ажилласан.		
УСАН ОРЧИН						
19	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Эргэлтийн усан сангийн чанарын үзүүлэлтийг хяналт тавих	ҮАЗ	Өмнө нь ашиглаж байсан нуурын усыг эргэлтэнд оруулж ашигласан.	Тийм	ҮАЗ
20		Жил бүр ус ашиглах дүгнэлтийг “Усны газар”-аас гаргуулах	250.0	2025 оны 06-р сарын 26-ны өдрийн E-2505-000410 дугаар бүхий ус ашиглуулах дүгнэлтийг Усны газраар гаргуулсан.	Тийм	645.0
21		Ундны усны чанарын үзүүлэлтийг шинжлүүлж, хяналт тавих	ОХШХ	Байгаль орчны мэргэжлийн байгууллагаар мониторингийн ажил гүйцэтгүүлсэн.	Тийм	ОХШХ
АМЬТНЫ АЙМАГ						
22	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, хяналт тавих	200.0	Нийт ажилчдад байгаль орчны сургалт орж, ажилчдыг хууль бус ан агнуур хийж болохгүй талаар анхааруулж, хяналт тавьж ажилласан	Тийм	200.0
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /мян.төг/			1 050.0	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /мян.төг/		1 445.0

Зураг 2. Уурхайн тэмдэг тэмдэглэгээ





Зураг 3. Засварын талбайн суурийг ус үл нэвчих материалаар хучиж буй зураг



ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 онд техникийн нөхөн сэргээлтийг ордын зүүн хойд хэсэг буюу C3-C4 хэсэгт 0.15 га, техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийсэн. Уурхайн нөхөн сэргээлт хийдэг мэргэжлийн байгуулга буюу “Өвөр булан” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэсэн. 2024 оны 10 дугаар сарын 25 өдрөөс 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

2025 онд элс олборлолтын ажил 2025 оны 07-р сарын 01-ээс 08-р сарын сүүл хүртэл хийнэ гэж төлөвлөсөн боловч ил уурхайн бэлтгэл ажил болон бичиг баримтын бүрдлээс шалтгаалан 08-р сараас эхлэн ажилласан. Энэ онд уурхайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгээгүй.

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монголиан токен майнинг инвестмент групп корпорейшн” ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас ирүүлсэн саналын дагуу 5 га газрыг нөхөн сэргээсэн.


№	Дүйцүүлэн хамгаалах ажлын зорилт	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
1	Техникийн нөхөн сэргээлт	Орон нутгийн БО газраас санал болгосны дагуу талбайн орчимд эвдрэлд орж орхигдсон 5 га хүртэлх талбайг техникийн нөхөн сэргээлт хийх	1 000.0	Орон нутгаас өгсөн эвдрэлд орж орхигдсон 5 га талбайг нөхөн сэргээсэн	Тийм	10 000.0
2	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр	Мод тарих, аймгийн БО газраас санал болгосон зулзага голын нарсан ойг тэлэх, арчилгаа хамгаалалт, хашаажуулалт	1 000.0	Зулзагын нарсан ойг тэлэх ажилд оролцсон.	Тийм	5 000.0
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /МЯН.ТӨГ/			2 000.0	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /МЯН.ТӨГ/		15 000.0


Хүснэгт 2. Дүйцүүлэн хамгаалсан газрын координат

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	106	30	33.96	49	14	06.05
2	106	30	43.55	49	14	05.92
3	106	30	43.18	49	13	53.24
4	106	30	33.52	49	13	53.49

Зураг 4. Нөхөн сэргээсэн газрын зураг







**ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн талбайд ямар нэгэн айл өрх, өвөлжөө хаваржаа, худаг байхгүй учраас нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд 2024 онд археологи, палеонтологийн судалгаа хийгдсэн бөгөөд тус судалгаагаар ямар нэгэн түүхийн дурсгалт зүйлс олдоогүй болно. Иймд цаашид уурхайн ашиглалтын үе шатанд ямар нэгэн түүх, соёлын дурсгал илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж холбогдох арга хэмжээг авах болно.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
1	Хээрийн түймэр уурхайн талбай, кемп рүү орж ирэх, уурхай хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж, уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	ҮАЗ	Уурхайн талбайд олборлолтын бүсэд далан босгосон.	Тийм	ҮАЗ
2	Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гад түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй.	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	Уурхайн гамшиг эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон бусад холбогдох журмуудыг батлуулж ажилласан.	Тийм	ҮАЗ
		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	300.0	Ашиглалтын талбайд гал түймэр гарахаас сэргийлж сургалт явуулсан.	Тийм	300.0
		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	ҮАЗ	Галын хор болон галын буланг байрлуулж ажилласан.	Тийм	ҮАЗ
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	ҮАЗ	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ил гал гаргахгүй байх, тамхины шиг тогтоосон цэгт хаях зэргээр заавар өгч байсан.	Тийм	ҮАЗ
3	Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны дэвтэрт өдөр бүр ажил эхлэхээс өмнө зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулсан.	Тийм	ҮАЗ
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	500.0	ХАБ мэргэжилтэний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан. Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын зааварчилгааны дагуу холбогдох нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханган ажилласан.	Тийм	500.0
		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	ҮАЗ		Тийм	ҮАЗ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-021417 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	ҮАЗ			
4	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотор таних тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жолооч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан. Уурхайн дотоод замд тэмдэг тэмдэглэгээ тавьж ажилласан. Шаардлагатай газруудад таних тэмдэг байрлуулсан.	Тийм	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /мян.төг/			800.0	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /мян.төг/		800.0



НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэх зорилгоор Хонгор сумын “Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГ-тай “Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх гэрээ”-г байгуулж ажиллаж байна.

Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	ҮАЗ	Хонгор сумын “Хот тохижилт ОНӨААТҮГ”- тай гэрээ байгуулж ажилласан	Тийм	960.0
		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулах	ҮАЗ	Уурхайн ажилчдын байр болгонд хогийн сав байрлуулсан.	Тийм	ҮАЗ
		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	1 000.0	Хог хаягдлын тухай хуулийн 23.1.1-ын дагуу сард цуглуулсан аюултай хог хаягдлын хэмжээ 1000 кг хүрээгүй тул 180 хоног хүртэлх хугацаанд хадгалж байгаа.	Тийм	1 000.0
		Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх			Тийм	
		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсадад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	ҮАЗ	Хог хаягдлын хор уршиг, ялган ангилах талаар ажилчдад сургалт явуулж, бүртгэл хөтөлж байсан.	Тийм	ҮАЗ
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	ҮАЗ	Аюултай хог хаягдлын цэг нь бетонон суурьтай болно	Тийм	ҮАЗ
2	Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ҮАЗ	Төслийн явцад хийн хаягдал гараагүй	Тийм	ҮАЗ
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /мян.төг/			1 000.0	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /мян.төг/		1 960.0

Зураг 5. Уурхайн энгийн болон аюултай хог хаягдлын талбайн зураг





АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ
ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 05 сарын 14-ны өдөр

№ 38

Хонгор сум

Энэхүү гэрээг нэг талаас хуулийн этгээдийн 279902 улсын бүртгэлийн дугаар 4293754 регистрийн дугаартай Дархан- Уул аймаг Хонгор сум "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ (цаашид үйлчлэгч) тал гэх түүнийг төлөөлж Хог хаягдлын үйлчилгээний зохион байгуулагч Гансүх овогтой Нарантуяа нөгөө талаас хуулийн этгээдийн..... улсын бүртгэлийн дугаар регистрийн дугаартай түүнийг төлөөлж овогтой (цаашид "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ) тал гэх нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмыг удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл

1.1. Дархан-Уул аймаг Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ нь Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булж устгах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагааны үндсэн чиглэл, хог хаягдлыг тухай хуулийн хүрээнд захиалагч н өдөр тутмын ахуйн хог хаягдлыг хувиарын дагуу татан зайлуулах

1.2. Захиалагч тал хогоо тээвэрлүүлэхээр дуудлага өгсөн тохиолдолд "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ зориулалтын тээврийн хэрэгсэлээр захиалагчийн хог хаягдлыг татан зайлуулах.

1.3. Гэрээг 3 жилийн хугацаатай байгуулж сунгалт хийх , нэмэлт өөрчлөлт оруулах зарчмаар хэрэгжүүлэх ба хоёр тал тус бүр нэг хувийг хадгална.

Хоёр: Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг.

2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булж устгах эрх бүхий "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-тай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

2.2. Шаардлага хангасан хогийн савтай байх, хог хаягдлыг ачих нөхцөл боломжоор хангасан байх

2.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд Хонгор сумын "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-ын Хаан банкны 5054187159 тоот дансанд төлөх.

2.4. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, зохион байгуулалттай үйл ажиллагаанд

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.06.06 16:32:20

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 252509556

Системийн огноо: 2025.06.06

Нэр: МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК

Илгээгч	Дансны дугаар:	Нэр	Дүн	Ханш
	821010565	МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК	960,000.00 MNT	1.00
/ есөн зуун жаран мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 05 Дансны дугаар MN690005005054187159	Банкны нэр Хаан Банк Нэр ОТ ТОХИЖИЛТДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ХОНГОР Х	960,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

EB - 2025 оны Хогны гэрээний төлбөр-Монголиан Token Майнинг ХХК-6438776

Танд баярлалаа

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2025 онд байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар орчин, хөрсөн бүрхэвч, усан орчноос дээж авахаар төлөвлөсөн болно. Төлөвлөгөөний дагуу байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Мейк грийн” ХХК-тай гэрээ байгуулан мониторингийн ажлыг гүйцэтгэлээ.

№	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
Агаарын чанар	Агаарын тоосны шинжилгээг хийлгэх /Нийт тоосонцор, PM10, PM2.5/	156.8	“Мейк грийн” ХХК-тай гэрээ байгуулан мониторингийн ажлыг гүйцэтгэлээ.	Тийм	4 400.0
	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO2, NO2/				
	Угаарын хий тодорхойлох				
	Дуу шуугиан				
Хөрсний бохирдол	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	80.0			
	Хүнд металлын агууламж	132.0			
	Эрүүл ахуй	50.0			
Усны чанар	Химийн ерөнхий шинжилгээ	96.0		Тийм	
	Микробиологийн шинжилгээ				
	Усны түвшин усны ундарга, нөөц				
Ургамлын аймаг	Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	500.0		Тийм	
	Нөхөн сэргээсэн талбайн ургамлын хяналт	500.0			
	Тарьсан модны өсөлт, амьдралын тооллого	200.0			
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /МЯН.ТӨГ/		1 714.8	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /МЯН.ТӨГ/		4 400.0

АРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Аймаг, сум, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээний тухайд: Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179-р тогтоолын дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын засаг даргатай 2025 оны 08-р сарын 12-ны өдрийн 25-to-08-12-A тоот хамтын ажиллагааны гэрээг байгуулж ажилласан.

№	Төлөвлөгөө	Төлөвлөсөн төсөв /мян.төг/	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
1	-	-	Хамтран ажиллах гэрээ	Тийм	50 000.0
2	-	-	Хүүхдийн баяраар 100 бэлэг өгсөн	Тийм	3 500.0
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨВ /МЯН.ТӨГ/		-	БИЕЛЭЛТ ТӨСӨВ /МЯН.ТӨГ/		53 500.0

БАТЛАВ.
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБААТАР



LUO XIAOYONG

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2025 оны 08-р сарын 12-ны өдөр

№ 25-to-08-12-A

Буурал

Энэхүү гэрээг нэг талаас Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргыг төлөөлж, Засаг даргын орлогч Т.Нинжбадам /цаашид "Засаг даргын орлогч" гэх/, нөгөө талаас MV-021417 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК /РД:6438776/-ийг төлөөлж, гүйцэтгэх захирал Luo XiaoYong /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны дугаар сарын.....-ны өдөр Дархан-Уул аймаг Хонгор суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн аймгийн Засаг даргатай байгуулна.

Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг дарга дараах эрхийг хэрэгжүүлнэ.

2.1.1 гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.2 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хяналт тавих;

2.1.3 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

2.2 Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг даргын дараах үүргийг хэрэгжүүлнэ.



**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Төлөвлөгөө	Төсөвлөсөн төсөв	Хэрэгжилт	Биелсэн эсэх	Биелэлт төсөв /мян.төг/
1	Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах	-	2025 онд нөхөн сэргээлт хаалт хийгээгүй	Үгүй	ҮАЗ
2	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх тухай гэрээг байгуулсан.	Тийм	Тохиролцох
Төсөвлөсөн төсөв		-	Биелэлт төсөв /мян.төг/	-	-

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төсөл хэрэгжүүлэгч “Монголиан токен инвестмент групп корпорейшн” ХХК нь БОМТ ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналтат дор ажилласан. Тус ажлыг ҮАЗ-аар гүйцэтгэсэн.

- Уурхайн үйл ажиллагааг аймаг, сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, аймгийн БОАЯЖ, Хараа-Ерөө голын сав газрын холбогдох мэргэжлийн хүмүүст болон экологийн цагдаагийн хэлтэс-т газар дээр нь танилцуулсан.
- Орон нутгийн болон уурхайн нөлөөллийн бүсэд орших айлууд нь баруун аймгуудаас шилжин ирж суурьшсан айлууд байсан бөгөөд тус айл, өрхүүдтэй найрсаг харилцаатай сүү цагаан идээ болон, мах, махан бүтээгдэхүүнийг малчин өрхүүдээс авч хэрэглэж байсан.

**АРВАН ГУРАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ**

“Монголиан токен майнинг инвестмент групп корпорейшн” ХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Санжит” нэртэй MV-021417 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ТЭЗҮ-ийн дагуу болон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр ажиллаж чадаагүй болно. Эхний жил уурхайн бэлтгэл ажил болон холбогдох зөвшөөрөл бичиг баримтын бүрдүүлэхээс шалтгаалан уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж чадаагүй гэвч Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу холбогдох бүх зөвшөөрлийн бичиг баримтыг бүрдүүлэн ажилласан болно.

Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Зардлын утга	Төлөвлөгөө /мян.төг/	Биелэлт /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	1 050.0	1 445.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5 964.7	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2 000.0	15 000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800.0	800.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 000.0	1 960.0
8	Удирдлага зохион байгуулалтын зардлын төлөвлөгөө	-	-
9	Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр	1 714.0	4 400.0
10	БОМТ-г орон нутагт тайлагнах	-	-
Нийт	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	12 529.47	18 605.0
	Орон нутагтай хамтран ажиллах гэрээний биелэлт дүн	-	53 500.0
НИЙТ ДҮН		12 529.47	77 105.0